

II- бүлэг Хувь хүн ба соёл

Сэдэв: Бид нутгийнхаа өв соёлоор бахархдаг

Хамрах хүрээ: 8-р анги

Соёл гэж юу вэ?

Соёл гэж хүний байнгын, идэвхтэй, чөлөөт үйл ажиллагааны үр дүнд бий болж уламжлагдаж байдаг хэм хэмжээ, итгэл үнэмшил, билэг тэмдэг, үнэт зүйлсийн цогц, хүний хөгжсөн түвшин юм. Өөрөөр хэлбэл соёл нь хүний ололт амжилтын цогц юм.

Соёл нь тухайн нийгмийг бусад нийгмээс ялгах шинж, тухайн нийгмийн хөгжлийнх нь үндэс төдийгүй хүмүүс хойч үедээ өвлүүлдэг үнэт зүйл юм.

Соёлыг бүтээгч болон тээгчээс нь шалтгаалж дараах бадлаар ангилдаг.

- ❖ Хувь хүний соёл
- ❖ Бүлэг байгууллагын соёл
- ❖ Орон нутгийн соёл
- ❖ Улс үндэсний соёл
- ❖ Нийт хүн төрөлхтний соёл



- Соёл нь тухайн нийгмийг бусад нийгмээс ялгах шинж, тухайн нийгмийн хөгжлийнх нь үндэс төдийгүй хүмүүс хойч үедээ өвлүүлдэг үнэт зүйл юм.
-



Аливаа улс орны үнэт зүйл баялаг нь хүн юм.



-
- Хүний хөгжих бололцоо, орчин нь хэр хөгжсөн, хүн амын өсөлт эрүүл мэнд, амьдралын түвшин ямар байгаа, байгаль цаг уурын өөрчлөлт зэрэг үзүүлэлт нь тухайн орон нутгийн соёлын чухал үзүүлэлт болдог.



Мөн соёлын чухал үзүүлэлтийн нэг нь:

Түүхийн дурсгалт зүйлс орно. Эдгээр дурсгалт зүйлсийг нутгийн зон олон хүндэтгэн эрхэмлэсээр ирсэн бөгөөд хойч үедээ өвлүүлэн үлдээдэг.

Түүхийн дурсгалт зүйл:



Хүний болон хүн, байгаль хоёрын харилцан үйлчлэлийн дүнд бий болсон гайхамшигт бүтээл юм.

Тэгвэл бүх талын ач холбогдол бүхий түүхийн дурсгалт зүйлсийг багтаасан бүс нутгийг дурсгалт газар гэж нэрлэдэг.



Зургал-2. Түүхийн дурсгалт зүйлсийн тусламж

- Тухайн түүхийн дурсгалт зүйлс нь орон нутгийн соёл, аялал жуучлалыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй.
-

Аялал жуулчлал нь тухайн орон нутгийн ард түмний амьдралын хэв маяг, өв соёлтой газар дээр нь танилцдаг соёлын харилцааны онцгой хэлбэр юм.





Оюуны соёл

Соёл



Материаллаг соёл

❑ **Материаллаг соёлд:** Байшин барилга, хөшөө дурсгал, археологийн олдвор, машин техник гэх мэт биет зүйлс хамаарна.

❑ **Оюуны соёлд:** шашин, домог үлгэр, зан заншил баяр наадам, шинжлэх ухаан, мэдлэг боловсрол, урлаг гэх мэт биетээр орших боломжгүй зөвхөн хүний оюун санаагаар дамжин өвлөгддөг зүйлсийг багтаадаг.



Дараах асуултанд хариулна уу?

- Орон нутгийн соёл гэдгийг өөрийн үгээр тайлбарлана уу?
- Танай нутгийн гол бахархал болсон үнэт зүйл юу вэ?

Соёл бол хэм хэмжээ мөн

- Соёл нь нийт хүн төрөлхтний зүгээс хойч үеийнхэндээ өвлүүлэн үлдээхийг хүсэж байдаг үнэт зүйлс.

Соёлыг хэм хэмжээ талаас нь судлан ойлгоно гэдэг нь: Амьдарч аж төрж буй орчиндоо хэрхэн биеэ авч явах, бусдын соёлд хэрхэн хандах талаар судлана гэсэн үг юм.



Хүмүүс бүхий л амьдралынхаа туршид ямар нэг соёлын орчинд амьдарч байдаг.

Хүмүүс тухайн соёлоос суралцаж, дагаж мөрдөж,
үнэлэлт дүгнэлт өгч байдаг.

Тухайлбал: хүмүүс хэн нэгний авир байдалд “соёлтой”, “соёлгүй”, “бүдүүлэг” гэсэн ойлголтуудыг хэрэглэн үнэлгээ өгдөг. Өөрөөр хэлбэл соёл нь хүнд эерэг зохистой, бас зохисгүй шинж байдлын хэмжүүр болж байдаг.

Соёл нь нийгмийн бүх гишүүдийн даган мөрддөг эрхэм чанар, хэм хэмжээг илэрхийлж байдаг. Тухайлбал үнэнч, шудрага байх, хүмүүнлэг байх, нэр төрөө эрхэмлэх, амхад үеэ хүндэтгэх, байгаль орчноо хайрлах хамгаалах зэрэг хэм хэмжээнүүд нь бидний эрхэмлэдэг хэм хэмжээнүүд юм. Жнь. Үнэнч байхыг эрхэмд үзвээс худлаа хэлэх, хууран мэхлэхийг шүүмжилнэ.

Хамтран ажиллаарай.

- Сурах бичиг: хуудас 32



ХЭМ ХЭМЖЭЭ



Албан бус хэм
хэмжээ
(зан заншил, ёс
суртахуун)

Албан хэм хэмжээ
(хууль, дүрэм)

Зан заншил

- Буруу зөв гэж хатуу үнэлдэггүй ч хүмүүсийн амьдралд байнга давтагддаг мөрдөлгөөнүүд ёс заншил багтана. Жнь: бусдын мэндийг мэдэх, хувцсаа зөв зохистой өмсөх....

Ёс суртахуун

Энэ хэм хэмжээ нь: Худал хэлэхгүй байх, хулгай хийхгүй байх, үүрэг хариуцлагаа эрхэмлэдэг байх гэх хүний зан араншин авир үйлдлийг зохицуулдаг. Ёс суртахуун нь зөв буруу, сайн муу гэж үнэлэгдэх бөгөөд сайшаах, урамшуулах, шийтгэх хөшүүрэгтэй хэм хэмжээ юм.

Албан хэм хэмжээ

Үүнд: Монгол улсын Үндсэн хууль болон бусад хууль дүрмүүд багтана. Албан хэм хэмжээг зөрчвөл хуульд заасан хариуцлага хүлээдэг.

Анхаарал хандуулсанд баярлалаа.